

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020 /4/СТА-ТТЗ

---

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Аудитор: П.Содном

Утас: 70342495

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |

|   |    |
|---|----|
| <b>Аудитын гэрчилгээ</b> .....  | 3  |
| Аудитын тайлан .....  | 5  |
| 2.1. Оршил .....  | 5  |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....   | 5  |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....   | 6  |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....   | 6  |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 7  |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....   | 8  |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....   | 8  |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....   | 8  |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....  | 9  |
| 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....  | 11 |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал  | 11 |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл .....   | 12 |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....   | 12 |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....   | 12 |
| Менежментийн захидал .....  | 13 |
| Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....   | 15 |
| 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....   | 15 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....   | 16 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....  | 19 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....  | 22 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....   | 23 |
| 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....   |    |

  
**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Могод сумын Засаг дарга  
Ц.Баярсайхан танаа

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

Дагд. 0/2 А. № 133

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ Т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Могод сумын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Могод сумын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын

006020193

стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ДАНХБАЯР

## 2.1. Оршил

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Ц.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 05- наас 2020 оны 03 дугаар сарын 25- ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүллээ.

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дүгээр сарын 03-ны өдрийн 01/65 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Булган аймгийн Могод сумын Засаг дарга нь сумынхаа хөгжил дэвшилд манлайлагч байж, НӨУБ-ыг төлөвшүүлэх, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотой шийдвэрлэхэд тэдний идэвх санаачилга, нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой тэнцвэрт хөгжлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрхэм зорилтын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж хэрэгжилтийг тооцож ажилласан.

- Иргэн төвтэй, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлнэ.
- Төр засгийн бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай үнэн зөв хүргэж, мэдээллийн чанар хүртээмж, ил тод байдлыг хангана.
- Онцгой байдал мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого боловсруулах, төлөвлөлтийн явцад тусгах, ашиглах чадавхыг бүх шатны байгууллагад бий болгон олон нийтийн оролцоог хангах, санхүүжүүлэх арга замыг тодорхойлон, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, үр нөлөөг дээшлүүлэх
- Цэрэг техникийн тоо бүртгэлийг хөтлөх, цэрэг татлагыг зохион байгуулах, цэргийн жинхэнэ болон бусад албыг хэвшүүлж, хэрэгжүүлэх
- Зэвсэгт хүчний анги байгууллагыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах Булган аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг хангах
- Төсөв, санхүүг хариуцлагатай, ил тод, үр ашигтай удирдаж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.
- Байгаль орчин, ногоон хөгжил
- Эдийн засгийн өсөлтийг дэмжин технологийн дэвшилд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялгийг бүтээн орлогыг нэмэгдүүлж, сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдралыг хамтдаа бүтээнэ.

Сумын Засаг даргын захирамжаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- (Төр эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа-1)
- (Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа-2)
- (Ерөнхий боловсролын сургалтын үйл ажиллагаа-3)
- (Соёл болон бусад нийгмийн үйлчилгээг зохицуулдаг төрийн байгууллагын үйл ажиллагаа-4)
- (Сумын эмнэлгийн тусламж үйлчилгээ-5)

Сумын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжууд Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Төсөв баталсан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Төсөв баталсан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох)
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох)
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн 228 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)
- Сангийн сайдын 2007 оны 11 дугаар сарын 30 -ны өдрийн 326 дугаар тушаал (Журам батлах тухай Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар)

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Могод сум нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Freebalance болон CTS программ хангамж ашигладаг байна.

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,663,076.5 мянган төгрөгөөс тооцон 53261.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 53261.5 мянган төгрөгөөр тооцлоо.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Могод сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,334.5 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

мянган төгрөг/

| Үзүүлэлт       | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт  |
|----------------|----------------|-----------------|-----------|
| Б              | 1              | 2               | 3=2-1     |
| Мөнгөн хөрөнгө | 145,715.9      | 174,045.6       | 28,329.7  |
| Авлага         | 136,001.0      | 132,973.0       | -3,028.0  |
| Урьдчилгаа     |                |                 |           |
| Бараа материал | 173,241.8      | 196,844.3       | 23,602.5  |
| Үндсэн хөрөнгө | 2,321,800.8    | 2,541,231.1     | 219,430.3 |

|   |             |             |           |
|---|-------------|-------------|-----------|
| <b>Нийт хөрөнгө</b>                               | 2,776,759.4 | 3,045,094.0 | 268,334.6 |
| Өр төлбөр   | 4,459.2     | 4,459.2     | -         |
| Засгийн газрын оролцоо<br>/Эздийн өмч/            |             |             |           |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | 1,552,999.4 | 1,821,334.0 | 268,334.6 |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлттэй холбоотой буурсан байна.

Бараа материал оны эцэст 27986.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь ашиглалтгүй бараа материалын үлдэгдлийг нэмэгдүүлэх талтай ч дараа оны төсвийг хэмнэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь акталсан болон шилжүүлсэн хөрөнгөнөөс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 83252.1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 56073.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 58161.6 мянган төгрөг, акталсан 45141.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Бусад 4459.2 мянган төгрөгийн өр нь он дамжсан эмийн өр үүссэн байна. Энэ нь орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Могод сум тайлант онд 101064.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 97939.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 97 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл                        | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Хувь  |
|--------------------------------------|------------|-----------|----------|-------|
| Үйл ажиллагааны орлого               | 1,000.0    | 2,145.6   | -1,145.6 | 214.5 |
| Шууд бус орлого                      | 32,140.0   | 28,601.8  | 3,538.2  | 89.0  |
| Хадгаламжийн хүүгийн татварын орлого | 37,879.0   | 44,915.0  | -7,036.0 | 118.6 |
| Бууны албан татвар                   | 8,294.0    | 3,026.0   | 5,268.0  | 36.5  |
| Улсын тэмдэгтийн хураамж             | 1,500.0    | 1,058.9   | 441.1    | 70.6  |
| Хог хаягдлын хураамж                 | 5,040.0    | 4,384.4   | 655.6    | 87.0  |

|   |                  |                 |                |             |
|---|------------------|-----------------|----------------|-------------|
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр                       | 200.0            | 152.0           | 48.0           | 76.0        |
| Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус рашаан ашигласны төлбөр | 2,500.0          | 1,502.0         | 998.0          | 60.0        |
| Ойгоос хэрэглээний мод, түдээ бэлтгэж ашигласны төлбөр                  | 4,445.0          | 4,143.3         | 301.7          | 93.2        |
| Ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хураамж                              | 866.0            |                 |                | 0           |
| Хүү торгуулийн орлого   | 6,000.0          | 8,010.2         | -2,010.2       | 133.5       |
| ТБӨО  | 1,000.0          | 869.0           | 131.0          | 86.9        |
| Нэр заагдаагүй орлого   | 200.0            |                 |                | 0           |
| <b>Нийт дүн</b>   | <b>101,064.0</b> | <b>98,808.2</b> | <b>2,255.8</b> | <b>97.8</b> |

Сумын татварын орлого 2,255.8 мянган төгрөгөөр тасарсан нь татварын байцаагчгүй 4 сар ажилласан мөн түүхий эдийн урамшууллын 10% дутуу орсноос шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 41 хөтөлбөрт зориулан 2,056,049.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1937957.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 118,091.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1848568.6 мянган төгрөгийг улсын, орон нутгийн төсвөөс, 29600.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 177,880.5 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 71952.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 51087.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1846431.7 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь төсвийг үр ашигтай зарцуулсан мөн хэмнэгдэж байгаа зардлаар төсөвт зохицуулалт хийж өр авлага үүсгээгүй ажилласантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар 2 байгууллага 2950.0, Засаг даргын нөөц хөрөнгө 13061.7, дээд шатны төсвийн захирагчаас 42128.0, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 220.8 нийт 58360.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 1889.1, багаж техник хэрэгсэлд 10000.0, бараа үйлчилгээний бусад зардалд 45904.3 нийт 57793.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 567.1 мянган төгрөгийг улсын, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 16766.8 мянган төгрөгийн алдаа, 5268.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 11498.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 11498.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Зөвлөмж өгөхөөс бусад алдаа, зөрчлийг шийдвэрлэсэн байдал:

Сумын татварын орлогоос үйл ажиллагаанаас үл хамаарах, ногдуулалт нь тодорхой бууны албан татварыг 8294.0 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 3026.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 5268.0 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасалсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1.1 "Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоосон

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Могод сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Могод сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 2000000 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй иргэнд 2019 онд СХС-гаас дахин 5000000 төгрөгийн зээл олгосон нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын хавсралтаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 6.1 дэх "Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд сангаас дахин зээл олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 16600.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 2000.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 9300.0 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 300.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 154 мэдээллээс... мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, дүгнэлт гэсэн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

#### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *3.1 Орлогын данстай холбоотой асуудал*

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг харьцуулсан дүнгээрээ 2124.7 мянган төгрөгөөр тасалсан, орлогыг нэр төрлөөр авч үзвэл шууд бус орлого 3538.2, бууны албан татвар 5268.0, улсны тэмдэгтийн хураамж 441.1, хог хаягдлын үйлчилгээний хураамж 655.5, ус рашаан ашигласны төлбөр 998.0, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 866.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан бол үйл ажиллагааны орлого 1145.5, хөрөнгийн орлого 7035.9 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэнд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.**

### **3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 16600.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 2000.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож,

9300.0 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 300.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

**3.2.2 Эрсдэл:**

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй**

**3.3 Удирдлагатай холбоотой асуудал**

**3.3.1 Илрүүлэлт:**

Могод сумын сум хөгжүүлэх санд 2000000 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй иргэнд 2019 онд СХС-гаас дахин 5000000 төгрөгийн зээл олгосон нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын хавсралтаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 6.1 дэх "Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд сангаас дахин зээл олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Эрсдэл:**

Хууль журам, зөрчигдөх.

**3.3.2 Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын хавсралтаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам" мөрдөн ажиллах.

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй**

Төсвийн захирагч зөвшөөрсөн Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл              | Эцсийн үлдэгдэл             |
|-------------|------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | <b><u>454958639.15</u></b>  | <b><u>503862808.09</u></b>  |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | 145715860.85                | 174045550.00                |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>  | 145715860.85                | 174045550.00                |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                      | 145715860.85                | 174045550.00                |
| 31211       | Төрийн сангийн харилцах            | 145,686,212.46              | 174,023,755.00              |
| 31213       | Арилжааны банк дахь харилцах       | 29648.39                    | 21795.00                    |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                      | 136000995.48                | 132972999.49                |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                | 136000995.48                | 132972999.49                |
| 3351        | Байгууллагаас авах авлага          | 1834436.48                  | 531625.49                   |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага         | 134166559.00                | 132441374.00                |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 173241782.82                | 196844258.60                |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>          | 10121471.30                 | 13482912.54                 |
| 35130       | Эм боох материал                   | 10121471.30                 | 13482912.54                 |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>         | 161723111.52                | 182087146.06                |
| 35410       | Бичиг хэргийн материал             | 5179767.00                  | 5738755.00                  |
| 35420       | Аж ахуйн материал                  | 29778049.48                 | 32046736.48                 |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл                    | 30000.00                    | 30000.00                    |
| 35440       | Түлц, шатах тослох материал        | 3402800.00                  | 2070940.00                  |
| 35460       | Хүнсний материал                   | 6680672.96                  | 11940224.50                 |
| 35470       | Бусад хангамжийн материал          | 116651822.08                | 130260490.08                |
| 35600       | Мал амьтад                         | 1397200.00                  | 1274200.00                  |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | <b><u>2321800785.70</u></b> | <b><u>2541231145.94</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 2321800785.70               | 2541231145.94               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                | 2209651785.70               | 2429172145.94               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц     | 2176350522.50               | 2550622642.82               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл              | 458208353.83                | 628467957.74                |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл             | 210078035.00                | 210484000.00                |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл              | 74053910.88                 | 91528394.89                 |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)  | 371576905.01                | 417421959.21                |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл              | 164700657.13                | 216198926.65                |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил        | 195137006.36                | 229877603.59                |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл              | 102336921.92                | 111247522.93                |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө               | 43758739.14                 | 60758739.14                 |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл              | 20302507.55                 | 26889925.61                 |
| 39217       | Ном                                | 32352929.00                 | 34339929.00                 |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>            | 112149000.00                | 112059000.00                |
| 39301       | Програм хангамж                    | 2050000.00                  | 2050000.00                  |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл              | 645000.00                   | 735000.00                   |

|             |   |                             |                             |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 110744000.00                | 110744000.00                |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>2776759424.85</u></b> | <b><u>3045093954.03</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b><u>4459248.00</u></b>    | <b><u>4459248.00</u></b>    |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 4459248.00                  | 4459248.00                  |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | 4459248.00                  | 4459248.00                  |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>  | 4459248.00                  | 4459248.00                  |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг  | 4459248.00                  | 4459248.00                  |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>2772300176.85</u></b> | <b><u>3040634706.03</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 2772300176.85               | 3040634706.03               |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1219300710.97               | 1219300710.97               |
| 51101       | Өмч: - төрийн   | 1219300710.97               | 1219300710.97               |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 110569086.64                | 378903615.82                |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | 1,362,445,526.95            | 110,569,086.64              |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | (1,251,876,440.31)          | 268,334,529.18              |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 1442430379.24               | 1442430379.24               |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>2776759424.85</u></b> | <b><u>3045093954.03</u></b> |

#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл  | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>            | <b>2160070275.84</b> | <b>2930963084.00</b>  |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                            | <b>88682499.40</b>   | <b>89929093.43</b>    |
| <b>110</b>  | <b>Орлогын албан татвар</b>                       | 68488219.40          | 75662408.36           |
| <b>1100</b> | <b>Хувь хүний орлогын албан татвар</b>            | 68488219.40          | 75662408.36           |
| 110002      | Үйл ажиллагааны орлого                            | 1038638.00           | 2145563.15            |
| 110003      | Хөрөнгийн орлого                                  | 39850946.40          | 44914998.65           |
| 110008      | Шууд бус орлого                                   | 27598635.00          | 28601846.56           |
| <b>113</b>  | <b>Хөрөнгийн албан татвар</b>                     | 8008000.00           | 3026000.00            |
| 113002      | Бууны албан татвар                                | 8008000.00           | 3026000.00            |
| <b>118</b>  | <b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>              | 12186280.00          | 11240685.07           |
| <b>1180</b> | <b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>              | 6691800.00           | 5595335.07            |
| 118001      | Улсын тэмдэгтийн хураамж                          | 1687300.00           | 1058900.00            |
| 118006      | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 200000.00            | 152000.00             |
| 118009      | Хог хаягдлын үйлчилгээний хураамж                 | 4804500.00           | 4384435.07            |
| <b>1182</b> | <b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>            | 5494480.00           | 5645350.00            |
| 118201      | Ойн нөөц ашигласны төлбөр                         | 3683480.00           | 4143350.00            |
| 118203      | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр                 | 1811000.00           | 1502000.00            |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                        | <b>228377972.41</b>  | <b>580282171.46</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                | 228377972.41         | 578332171.46          |
| 120002      | Хүүгийн орлого                                    | 4837073.00           | 8010177.00            |
| 120003      | Торгуулийн орлого                                 | 128000.00            |                       |

Могод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

|             |   |                      |                      |
|-------------|---|----------------------|----------------------|
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 223412899.41         | 570321994.46         |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 84550888.00          | 71408294.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 138862011.41         | 498913700.46         |
| <b>122</b>  | <b>Тусламжийн орлого</b>  |                      | 1950000.00           |
| 122001      | Хандив тусламж /дотоод/   |                      | 1950000.00           |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>1843009804.03</b> | <b>2260751819.11</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 1127254900.00        | 1149091000.00        |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих  | 1127254900.00        | 1149091000.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 65223650.00          | 58360550.00          |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 500000.00            | 2950000.00           |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7215000.00           | 13061700.00          |
